

Их Эзэний бүхнээ зориулах хууль

Сургаал ба Гэрээнүүд 42:30, 38–39

Сургаал ба Гэрээнүүд 78:3–7

Сургаал ба Гэрээнүүд 105:1–5

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон ийн тайлбарласан.



Их Эзэний бүхнээ зориулах хууль (жишээ нь: С &ба Г 42:32, 53-ыг үзнэ үү) . . . эдийн засгийн үүргээсээ илүү энэ амьдралд болон ирээдүйд селестиел хуулийг хэрэгжүүлэх явдал юм (С &ба Г 105:5-ийг үзнэ үү). Өргөл болгох гэдэг нь аливаа зүйлийг нандин болгож, ариун зорилгод зориулахын тулд онцгойлон адислахыг хэлнэ. Энэ амьдралын жинхэнэ амжилт нь өөрсдийн амьдралыг, цагаа болон сонголтуудаа Бурханы зорилгод зориулан өргөл болгох үед л ирдэг (Иохан 17:1, 4; С &ба Г 19:19-ийг үзнэ үү). Энэ тохиолдолд Тэрээр биднийг хамгийн дээд хувь тавилангийнхаа оргилд хүрэх боломжтой болгодог билээ. (Д.Тодд Кристоффэрсон, “Өргөл болгосон амьдралын тухай бодол эргэцүүлэл,” 2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 17)

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф ийн заасан.



Золиослох, бүхнээ зориулах гэдэг нь дуулгавартай дагана хэмээн ариун сүмд гэрээлдэг тэнгэрлэг хоёр хууль юм. Энэ хоёр хууль ижил төстэй боловч хоорондоо адилгүй. . . .

Бүхнээ зориулах нь дор хаяж нэг чухал талаараа золиослолоос ялгаатай. Бид ямар нэг зүйлд бүхнээ зориулахдаа үүнийгээ тахилын ширээн дээр шатаж дуусгахаар үлдээдэггүй. Оронд нь бид үүнийг Их Эзэнд үйлчлэхэд ашигладаг. Бид үүнийг Түүнд болон Түүний ариун зорилгод зориулдаг. Бид бас Их Эзэний өгсөн авьяас чадварыг

аваад, Их Эзэний хаант улсыг байгуулахад илүү их тус нэмэр болохын тулд тэдгээрийг хэд дахин хөгжүүлэхийг хичээдэг.

Бидний дундаас маш цөөн хүнээс Аврагчийн төлөө амиа *золиослохыг* хүссэн. Гэхдээ бид бүх хүнийг амьдралаа Түүнд бүхэлд нь зориулахад урьдаг. (Дийтр Ф.Угдорф, “Сэтгэлийнхээ угаас,” *Лиахона*, 2022 оны 4-р сар, 8)

Бүхнээ зориулах хууль гэж юу вэ? Энэ нь надад хэрхэн нөлөөлөх вэ?

Өнөөдөр бид өөр өөр арга замаар энэ хуулиар амьдарч байна. Жишээлбэл: Бид бусдад үйлчилж, дуудлага болон Сүмийн үүрэг даалгавар хүлээн авч, чадах бүхнээ хийж, аравны нэгээ бүрэн төлж, мацгийн өргөлөө өгөөмрөөр өргөдөг. Бид Бурханы хаант улсыг өгсөн бэхжүүлж, тусламж хэрэгтэй хүмүүст туслахын тулд бошиглогчдын болон Ариун Сүнсний биднийг чиглүүлсэн зүйлийг хийдэг байвал бүхнээ зориулах хуулийн дагуу амьдарч байгаа хэрэг юм. (“Бүхнээ зориулах хууль гэж юу вэ? Энэ нь надад хэрхэн нөлөөлдөг вэ?,” *Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө*, 2021 оны 4-р сар, 31)